

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.04.25

Замын-Үүд сум

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 сарын 25-ны өдөр цахимаар 10 цагаас эхлэв.

Хурлын дэгийг Хурлын дарга Э.Батболд уншиж танилцуулсны дараа дэгийн дагуу тооллогын комиссын ирцийн тогтоолыг хурал зохион байгуулах хорооны гишүүн Б.Онон танилцуулснаар хурлыг эхэллээ.

“Э-Транс ложистикс” ХК нь нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцаатай бөгөөд нийт саналын эрх бүхий хувьцааны 93,52% хувь буюу 43,206,646 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
4. Компанийн 2022 оны стратеги төлөвлөгөөг батлах
5. ТУЗ-ийн 2022 оны цалин урамшууллын төсөв батлах
6. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Компанийн ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа:

Компанийн 2021 оны санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг танилцуулав. Компани нь 2021 санхүүгийн тайландаа Их Монгол хөлөг ХХК-ны аудитын компаниар аудитаа хийлгэсэн. Өмнөх жилүүдэд аудитаа хийлгэж байсан Нийслэл аудит ХХК-тай гэрээний хугацаа дууссан бөгөөд Их Монгол хөлөг ХХК-ны аудитын компанийг сонгож аудитаа хийлгэсэн болно. Энэхүү компани нь манай компанийн санхүүгийн байдалд аудит хийгээд зөрчилгүй дүгнэлт гаргасан байгаа үүнд Э-Транс ложистикс ХК-ны 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болох нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ. Бидний дүгнэлтээр санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шудаагаар толилуулсан байна гэж дүгнэж байна гэсэн дүгнэлт уншиж танилцуулав. Аудитлагдсан санхүүгийн тайлан дах Санхүүгийн байдлын талаар дараах мэдээллийг танилцуулсан. 2021 онд эргэлтийн хөрөнгийн дүн 338,700,064.95, эргэлтийн бус хөрөнгийн дүн 4,814,828,073.79 нийт хөрөнгийн дүн 5,153,528,138.74 төгрөг байна, богино хугацаат өр төлбөрийн дүн

54,847,931.49 төгрөг урт хугацаат өр төлбөр байхгүй, ингээд нийт өр төлбөр бас эздийн өмчийн дүн 5,153,528,238.74 төгрөг болж байна.

Компанийн Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

Хурлаар хэлэлцэх асуудлуудын дагуу компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, компанийн өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулав. 2021 он бол улс орон, дэлхий даяар хорио цээр, цар тахлын хүнд хэцүү жил болж өнгөрлөө. Гэвч энэ хүнд цаг үеийг үл харгалзан бид бүхий л бололцоогоо дайчлан ажиллаж 2021 онд бизнес төлөвлөгөө болон хийж гүйцэтгэхээр заасан бүх төлөвлөсөн ажил үйлчилгээнүүдээ өөрсдийн бололцоо нөхцлийн дагуу сайн хийж ажилласан. Цар тахалтай холбоотойгоор 2021 оны 10 сарын 15-наас хил бүрэн хаагдаж 2022 оны 02 сарын 24-нөөс зөвхөн чингэлэгээр ачаа зөөнө гэсэн учраас манайх бол үндсэндээ тодорхой хэмжээнд хаалттай байж байна гэвч манайх гаалийн хяналтын бүс учраас бүрэн хааж явж болохгүй учраас гаалийн хяналтын бүсэд явагдаж байгаа үйл ажиллагаанууд бүрэн дүүрэн ажилласаар явсаар байна. Тайлан мэдээнүүд та бүхэнд хүргэгдсэн болохоор тайлангаас асууж тодруулах зүйлээ асуугаад явъя гэж бодож байна. Та бүхэн асуух зүйлээ асуулт хариултын үед асууна уу.

Компанийн ТУЗ-ийн дарга Э.Батболд:

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг уншиж танилцуулав. Компани нь оны эхэнд ихээхэн эерэг үр дүнтэй бүрэн хүчин чадлаараа ажиллаж байсан ч 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс үндсэндээ бүрэн зогсолт хийсэн байх ба энэхүү байдал 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл үргэлжилж тодорхой хэмжээнд үйл ажиллагаануудаас олж байсан орлого тасалдсан бөгөөд хилээр чингэлгийн тээвэр явагдаж эхлэхэд тухайн компаниас өөрсдийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадалд тохируулан чингэлэг тээврийн хяналтын бүсээрээ дамжуулахаар ярилцаж шийдвэрлүүлэн 37 чингэлэг шилжүүлэн ачсан боловч гааль, мэргэжлийн хяналтын байгууллагаас зарим шаардлагыг тавьж энэхүү ажлыг зогсоожээ. Төмөр замаар шилжүүлэн ачих ачаа мөн хилийн асуудлаас болж орж ирэхгүй байгаа боловч хорио цээрийн дэглэм тавигдахаас өмнө төмөр замаар шилжүүлэн ачих ачаа барааны тоо нэлээн өсөх хандлагатай байсан нь 10 сарын 15-ны байдлаар нийт 344 вагонд ачаа шилжүүлэн ачиж 96,913.6 сая төгрөгний орлого олсон байгаагаас харагдаж байна. / 2020 онд төмөр замаар 565 вагон ачаа шилжүүлэн ачиж / 221 вагон нь цемент / 78,103.04 сая төгрөгийн орлоготой байсан /. Энэ жилийн хувьд автокранаар задгай вагонд төмөр шилжүүлэн ачих үйлчилгээний тоо хэмжээ ихссэн ба энэхүү үйлчилгээний хураамжийг тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нэмсэн байсан нь шилжүүлэн ачилтын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Үүнээс гадна хяналтын бүсийн үйл ажиллагаа, гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа өмнөх жилийн мөн үеэс өндөр ачаалалтай ажилласан нь тухайн үйлчилгээнээс олсон орлого 31-38 хувиар өссөнөөс харагдаж байна. Хил хаахаас өмнө тухайн хяналтын бүсэд 14677 тээврийн хэрэгсэл нэвтэрч хяналтын бүсэд орсон тээврийн хэрэгслийг хадгалсны хураамж 486,176.42 төгрөг, гаалийн баталгаат агуулахад ачаа бараа хадгалсны хураамж 721,125.90 төгрөг нийт үндсэн үйл ажиллагаанаас 1,392,214.12 төгрөгний орлоготой ажилласан байна. Харин бусад үйл ажиллагаанаас олсон орлого нэлээн хэмжээгээр буурсан нь зарим үйлчилгээний доголдоос үүсэлтэй байна. Хил хаагдаж үйл ажиллагаа бүрэн зогссон ч үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого

өмнөх жилийн мөн үеийнхтэй ижил хэмжээнд байсан нь санхүүгийн жилийн тайлангаар 262,398,749.26 төгрөгийн цэвэр ашигтай гарсанаар харагдаж байна. Иймд компани ашигтай ажилласан байна гэж үзэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нэгж хувьцаанд 1 төгрөг байхаар 46,200,000 төгрөгний ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэлээ. Гэхдээ нэгж хувьцаанд ногдох ашгийг нэмэгдүүлэх боломжтой байсан ч компанийн цаашдын үйл ажиллагааны төлөв, цар тахлын нөхцөл байдлыг тооцон үзэж дээрх шийдвэрийг гаргасан болно

Компанийн гүйцэтгэх захирл Ч.Амарсанаа:

Компанийн 2022 оны стратеги төлөвлөгөөг танилцуулав. Компани бол 2022 оны стратеги төлөвлөгөөгөө боловсруулахдаа зөвхөн тухайн жилийнхийг биш түүнээс урт 3-5 жилийн байдлаар төлөвлөөд явж байхаар тооцоолоод явж байна. Иймд 5 жилийн зорилт нь 2 тэрбум төгрөгийн орлоготой, 30%-ийн цэвэр ашиг олдог байхаар зорилт тавиал ажиллаж байна. Харин 3 жилийн дараах компанийн байдал бол бүрэн автоматжуулсан шилжүүлэн ачилтын цогцолбортой, орон нутагтаа болон бусад нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаараа танигдсан, шилжүүлэн ачилт, гаалийн хяналтын бүс баталгаат агуулахаар үйлчлүүлэгчдийн 80% нь тус компаниар үйлчлүүлэх сонирхолтой, нэгдсэн удирдлагаар хангадаг тогтолцоотой, маркетингийн бие даасан багтай, хөргөлтийн болон вакуумжсан 2-3 агуулахтай, цайны газраар үйлчлүүлэгчдийн тоо өссөн, Замын-Үүд суманд хоол үйлдвэрлэлээрээ танигдсан, үйл ажиллагаандаа мөрддөг црамшуулал, хөнгөлөлтийн цогц бодлоготой болсон байна гэж үзэж байгаа юм. Энэ жилийн хувьд 1.6 тэрбумыг орлоготой үүний 300 сая төгрөг нь ашиг болж 14,3%-ийн өсөлттэй байхаар төлөвлөж ажиллаж байгаа ба эхний ээлжинд доор дурьдагдсан ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд нэн тэргүүнд калмар зэрэг техникүүд явах зориулалт бүхий хатуу хучилттай замтай болох энэ нь бол 11280м² талбайг хатуу хучилттай болгох асуудал ярьж байгаа юм, үүний дараа ямар ч байсан нэг калмартай болох одоохондоо судалгаа хийж байгаа хараахан шийдвэрлэх болоогүй байна, дараагийн том ажил бол 2 агуулахаа зориулалтын битүү тоос шороо ордоггүй битүүмжлэлтэй нэг нь хөргөлттэй нэг нь хөргөлтгүй агуулахыг бүрэн тохижуулах асуудал байгаа юм, өөрсдийн компанийн урсгал засвар тохижолтын ажлууд мөн хийгдэнэ гэсэн төлөвлөгөөтэй байна.

Компанийн ТУЗ-ын дарга Э.Батболд:

Хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлын дагуу ТУЗ-д нэр дэвшигч нарыг танилцуулав.

Ердийн гишүүнд нэр дэвшигч нар:

1. Ч.Амарсанаа
2. Ч.Энхболд
3. Э.Батболд
4. Д.Даянбилгүүн
5. Б.Лхагвадорж
6. Ш.Шинэбаяр

Хараат бус гишүүнд нэр дэвшигч нар:

7. Х.Бат-Эрдэнэ
8. Ч.Оргил
9. Ж.Энхтулга

ТУЗ-ийн 2022 оны цалин урамшууллын төсөв батлах асуудлыг хүрээнд зардлын задаргааг уншиж танилцуулав.

Ногдол ашиг тараах талаар гаргасан шийдвэр:

1. “ Э-Транс Ложистикс “ ХК-ны 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 17,6 хувь буюу нэгж хувьцаанд 1 төгрөгөөр 46,200,000 хувьцаанд нийт 46.200.000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.
3. Ногдол ашиг хуваарилах ажлыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2022 оны 12 сарын 31-ний дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаад даалгасугай гэсэн тогтоолыг уншиж танилцуулав.

Хэлэлцсэн асуудалуудтай холбогдуулж асуулт асуух хувьцаа эзэмшигч байхгүй байсан тул асуулт хариулт, санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комисс хурлын шийдвэрийг танилцуулав.

Санал хураалтаар нийт хувьцааны 93,54% буюу 43,205,135 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч саналын хуудас бөглөн өгсөн.

Хэлэлцэх асуудал 1:

Саналын хуудсаар Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,205,135 ширхэг хувьцаа эзэмшиж бу хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,205,135	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 2:

Саналын хуудсаар Компанийн 2022 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,205,135 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,205,135	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 3:

Саналын хуудсаар ТУЗ-ын 2022 оны цалин урамшууллын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,205,135 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,205,135	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 4:

Саналын хуудсаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,205,135 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй саналын хуудсаар:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

	ТУЗ-ийн гишүүний нэр	ердийн	Саналын хувь	Кумулятив өгсөн саналын тоо	аргаар
1	Чулуун Энхболд		11,11%	43,205,135	
2	Чулуун Амарсанаа		11,11%	43,205,135	
3	Энхболд Батболд		11,11%	43,205,135	
4	Данзан Даянбилгүүн		11,11%	43,205,135	
5	Бүрэнмэнд Лхагвадорж		11,11%	43,205,135	
6	Шараа Шинэбаяр		11,11%	43,205,135	

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

	ТУЗ-ийн гишүүний нэр	хараат бус	Саналын хувь	Кумулятив өгсөн саналын тоо	аргаар
1	Чулуунбаатар Оргил		11,11%	43,205,135	
2	Жаргалсайхан Энхтулга		11,11%	43,205,135	
3	Хасаг Бат-Эрдэнэ		11,11%	43,205,135	

тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүнд сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүнд:

1. Энхболд Батболд
2. Чулуун Амарсанаа
3. Чулуун Энхболд
4. Данзан Даянбилгүүн
5. Бүрэнмэнд Лхагвадорж
6. Шараа Шинэбаяр

Хараат бус гишүүнд:

1. Чулуунбаатар Оргил
2. Жаргалсайхан Энхтулга
3. Хасаг Бат-Эрдэнэ

11:03 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулан хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга:



/ Э.Батболд /

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



/ С.Ганбат /



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2022.04.25

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны
тайлан, санхүүгийн тайлангийн талаар
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан,
санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж
үзсүгэй.
2. Стратеги төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч ажиллахыг
Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2022. 04 25

№ 02

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны стратеги
төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн 2022 оны стратеги төлөвлөгөөг баталсугай.
2. Төлөвлөгөөнд дурьдагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Ч.Амарсанаа/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2022. 04.25.

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг 4,560,000 төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2022.04.25.

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн "Э-Транс ложистикс" Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. "Э-Транс ложистикс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр
 - 1) Данзан ДАЯНБИЛГҮҮН
 - 2) Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
 - 3) Шараа ШИНЭБАЯР
 - 4) Чулуун АМАРСАНАА
 - 5) Чулуун ЭНХБОЛД
 - 6) Энхболд БАТБОЛД
2. "Э-Транс ложистикс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
 - 1) Хасаг БАТ-ЭРДЭНЭ
 - 2) Чулуунбаатар ОРГИЛ
 - 3) Жаргалсайхан ЭНХТУЛГА нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /



Хурлаар хэлэлцэх асуудал

*1. Компанийн санхүүгийн
тайлан, түүнд хийгдсэн хараат
бүе аудитын дүгнэлт;*

*2. Компанийн 2021 оны үйл
ажиллагааны тайлан;*

*3. 2021 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд
хийгдсэн МҮЗ-ийн дүгнэлт;*

*4. Компанийн 2022 оны
стратегий төлөвлөгөө;*

*5. МҮЗ-ийн 2022 оны цалин
уралшиууллын төсөв;*

*6. МҮЗ-ийн ердийн болон
хараат бүе гишүүдийг сонгож;*

*7. Ногодол ашгийн талаар
гаргасан шийдвэр танилцуулах;*



*2022 оны хувьцаа
эзэмшигчдийн ээлжит
хурал 2022.04.25*

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны
03 дугаар сарын 11-ний өдрийн №...-р
тогтоолын "Хавсралт №2"

"Э-ТРАНС ЛОЖИСТИК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт эхэлнэ.

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	10:00-10:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	10:10-10:15
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10:15-10:25
	Хурлаар хэлэлцэх асуудлууд	
4	Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт	10:25-10:35
	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан	10:35-10:45
	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах	10:45-10:55
	Компанийн 2022 оны стратеги төлөвлөгөөг батлах	10:55-11:05
	ТУЗ-ийн 2022 оны цалин урамшууллын төсөв батлах	11:05-11:15
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	11:15-11:20
	Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах	11:20-11:25
5	Асуулт хариулт	11:25-11:35
6	Саналын хуудас бөглөх заавар өгөх	11:35-11:40
7	Санал хураалт	11:40-11:55
8	Хурлын завсарлага	11:55-12:00
9	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	12:00-12:05
10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	12:05-12:15
11	Хурлыг хаах (хурлын дарга)	12:15-12:20

Хэлэлцэх асуудал 1

*Компанийн санхүүгийн
тайлан, түүнд хийгдсэн
аудитын дүгнэлт*





“ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ” ХХК
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ БИЗНЕС ЗӨВӨЛГӨӨ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо,
Төмөрчний гудамж, 8 дугаар байр, 1003 тоот
Утас: (+976) 7000 – 1778, Утас: (+976) 7000 – 1778,
И-мэйл: info@imkaudit.mn, Веб хуудас: www.imkaudit.mn

2022.03.31 № Д-2022/09

Танай _____ -ны № _____ -т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН
ДҮГНЭЛТ**

Зөрчилгүй дүгнэлт

Бид “Э-Транс ложистикс” ХК (цаашид “Компани”гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт(‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцүүлсэн байна.

ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2022 оны 03 сарын 31



Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	12/31/2020	12/31/2021
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	241,762,347.09	237,346,410.76
Дансны авлага	315,000.00	4,762,617.15
Татвар, НДШ-ийн авлага	0.01	801,818.19
Бусад авлага	1,937,883.00	-
Бараа материал	41,362,013.18	50,461,576.81
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	45,520,125.00	45,327,642.04
Эргэлтийн хөрөнгийн дүн	330,897,368.28	338,700,064.95
Үндсэн хөрөнгө	4,419,210,177.35	4,413,572,261.52
Биет бус хөрөнгө	476,792,679.91	401,255,812.27
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,896,002,857.26	4,814,828,073.79
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,226,900,225.54	5,153,528,138.74
Дансны өглөг	5,140,000.00	4,410,000.00
Татварын өр	14,706,508.21	37,469,748.69
Урьдчилж орсон орлого	220,000.00	500,000.00
Бусад богино хугацаат өр төлбөр	11,818,181.80	12,468,182.80
Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,884,690.01	54,847,931.49
Бусад урт хугацаат өр төлбөр	128,000,000.00	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	128,000,000.00	-
Өр төлбөрийн дүн	159,884,690.01	54,847,931.49
Хувийн өмч	4,620,000,000.13	4,620,000,000.13
Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00	154,000,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00	774,858,080.00
Хуримтлагдсан ашиг	(481,842,544.60)	(450,177,872.88)
Эздийн өмчийн дүн	5,067,015,535.53	5,098,680,207.25
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,226,900,225.54	5,153,528,138.74

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	12/31/2020	12/31/2021
Мөнгөн орлогын цэццдүн	1,310,707,615.78	1,630,815,457.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,304,470,241.94	1,621,761,221.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,829,367.00	8,000,626.00
Бусад мөнгөн орлого	408,006.84	1,053,610.00
Мөнгөн зарлагын дүн	864,351,113.17	1,122,054,130.18
Ажиллагчдад төлсөн	325,695,748.41	483,171,933.09
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,170,237.51	56,177,917.52
Бараа материал авахад төлсөн	72,307,024.00	153,230,166.20
Ашиглалтын зардалд төлсөн	111,046,864.09	64,163,191.20
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	57,699,670.00	53,776,043.44
Хүүгийн төлбөрт төлсөн	27,165,292.65	16,084,602.74
Татварын байгууллагад төлсөн	168,967,371.15	226,226,667.80
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	3,601,009.00	-
Бусад мөнгөн зарлага	73,697,896.36	69,223,608.19
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	446,356,502.61	508,761,326.82
Мөнгөн орлогын дүн	66,962,187.73	7,677,171.64
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	1,000,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт	66,859,637.00	4,017,946.99
Хүлээн авсан хүүгийн орлого	102,550.73	2,659,224.65
Мөнгөн зарлагын дүн	45,366,208.09	186,092,407.30
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	184,446,807.30
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	40,709,610.09	1,645,600.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	4,656,598.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,595,979.64	(178,415,235.66)
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	283,691,312.69	334,762,027.50
Бусад мөнгөн зарлага	283,691,312.69	128,000,000.00
Төлсөн ногдол ашиг	-	206,762,027.50
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(283,691,312.69)	(334,762,027.50)
Валютын ханшны зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	184,261,169.56	(4,415,936.34)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,501,177.53	241,762,347.09
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	241,762,347.09	237,346,410.75

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

**Аудитлагдсан санхүүгийн
тайлангаас**

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	12/31/2020	12/31/2021
Борлуулалтын орлого	1,202,586,431.82	1,416,649,910.00
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг/алдагдал	1,202,586,431.82	1,416,649,910.00
Түрээсийн орлого	41,181,817.91	57,818,181.82
Хүүгийн орлого	107,437.97	2,954,694.05
Борлуулалт маркетингийн зардал	953,462,545.36	1,174,246,235.61
Бусад зардал	12,300,000.00	11,012,342.55
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	11,881.84	(69.76)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	909,090.91
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	278,125,024.18	293,073,228.86
Орлогын албан татвар	6,365,375.31	30,408,557.14
Татварын дараах ашиг/алдагдал	271,759,648.87	262,664,671.72

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,620,000,000.13	154,000,000.00	774,858,080.00	(481,842,544.60)	4,913,015,535.53
Залруулсан үлдэгдэл	4,620,000,000.13	154,000,000.00	774,858,080.00	(481,842,544.60)	5,067,015,535.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	262,664,671.72	262,664,671.72
Зарласан ногдол ашиг	-	-	-	(231,000,000.00)	(231,000,000.00)
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,620,000,000.13	154,000,000.00	774,858,080.00	(450,177,872.88)	5,098,680,207.25

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

(Төгрөгөөр)	2020.12.31	2021.12.31
Аж ахуй нэгжийн орлогын албан татварын өглөг	2,910,420.34	2,275,603.13
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	10,086,673.34	8,163,538.29
Хувь хүний орлогын албан татварын өглөг	1,709,414.53	26,494,711.54
Дүн	14,706,508.21	37,469,748.69

18 Орлогын татварын зардал

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд орлогын албан татвар дараах байдалтай байна:

(төгрөгөөр)	2020	2021
Татвар төлөхийн өмнөх ашиг	278,125,024.80	293,073,228.26
Тусгай орлого	107,437.97	2,954,694.05
Хасагдахгүй зардал	12,300,000.00	11,012,342.55
Байнгын зөрүүгээр зохицуулагдах	290,317,586.83	301,130,876.76
Татварын түр зөрүү	-	-
Ханшийн бодит бус олз	11,881.80	(69.76)
Хэрэгжсэн олз	-	909,090.91
Түр зөрүүгээр зохицуулагдсан	290,329,468.63	302,039,897.91
Нийтлэг хувь хэмжээгээр суутгуулсан татвар	6,365,375.31	30,113,087.12
Тусгай хувь хэмжээгээр бусдад суутгуулсан	-	295,469.42

2020 оноос хэрэгжиж байгаа ААНОАТ-ын шинэ хуулийн дагуу тайлант үеийн Орлогын албан татварыг 10 хувиар ногдуулсан.

Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсч байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурилсан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтад байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь одоогийн үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлөвлөгөө, журмыг хэрэгжүүлж байгаа.

19 Эздийн өмч

Хувьцаат капитал нь тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байна.

Хувьцаа эзэмшигчид	Хувь эзэмшил	Эзэмшиж буй хувьцааны тоо	2020.12.31 (мянган төгрөг)	2021.12.31 (мянган төгрөг)
Э-Транс ложистикс ХК	50 %	23,100,000	2,310,000.0	2,310,000.0
Би Ди Сек ХК	28.5 %	13,179,669	1,317,966.9	1,317,966.9

Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Тасган инвест ХХК	11.0 %	5,092,835	509,283.5	509,283.5
Би Ди Пи Эй Эф ХХК	3.9 %	1,818,857	181,885.7	181,885.7
Бусад ААН	2.9 %	1,323,654	132,365.4	132,365.4
Монгол улсын иргэд	1.8 %	818,598	81,859.8	81,859.8
Гадаад улсын иргэд	1.9 %	866,837	86,683.7	86,683.7
НИЙТ ДҮН	100.0 %	46,200,000	46,200,000	46,200,000

Компанийн дүрмийн сан нь тайлант хугацааны эцэст нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 46,200,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Компанийн хуримтлагдсан ашгийн данс нь дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	Тайлан жилийн дүн
2020.12.31-ний үлдэгдэл	(481,842,544.60)
Хувиарласан ногдол ашиг	(231,000,000.00)
Тайлант жилийн цэвэр ашгаар нэмэгдсэн	262,664,671.72
2021.12.31-ний үлдэгдэл	(450,177,872.88)

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 02 сарын 08-ны өдрийн Тогтоолоор 2020 оны тайлант жилийн ашгаас 206,762,027.50 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд шилжүүлсэн.

20 Орлого

Борлуулалтын орлого дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2020	2021
Ачилтын орлого	78,103,040.00	96,913,600.00
Хадгалалтын орлого-гарах хуудасны орлого	669,406,375.45	752,232,000.00
Баталгаат агуулахын орлого	274,340,000.00	485,250,300.00
Бусад үйлчилгээний орлого	180,737,016.37	82,254,010.00
Түрээсийн орлого	41,181,817.91	57,818,181.82
Дүн	1,243,768,249.73	1,474,468,091.82

21 Борлуулалтын өртөг

Борлуулалтын өртөг дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2020	2021
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
Дүн	-	-

Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

22 Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2020	2021
Борлуулалт маркетингийн зардал	953,462,545.36	1,174,246,235.61
Дүн	965,762,545.36	1,174,246,235.61

23 Бусад орлого, зардал

23.1 Бусад орлого

Бусад орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2020	2021
Хандив тусламжийн орлого	-	-
Бусад орлого	-	-
Дүн	-	-

23.2 Бусад зардал

Бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2020	2021
Тэтгэмжийн зардал	12,300,000.00	11,012,342.55
Хөрөнгө акталж устгасны зардал	-	909,090.91
Дүн	12,300,000.00	11,012,433.46

24 Бусад ашиг, алдагдал

(Мянган төгрөгөөр)	2020	2021
Гадаад валютын ханшийн зөрүүний ашиг	11,881.84	-
Гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал	-	(69.76)
Дүн	11,881.84	(69.76)

25 Санхүүгийн орлого, зардал

(Мянган төгрөгөөр)	2021	2020
Санхүүгийн орлого	107,437.97	2,954,694.05
Санхүүгийн зардал	-	-
Дүн	107,437.97	2,954,694.05

26 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Компанийн удирдлага нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Түүнчлэн Компанийн удирдлага нь эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа өдөр тутам хийгдэж байгаа эсэхэд үүрэг хариуцлага хүлээдэг. Удирдлага нь хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааныхаа талаар тайлагнадаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон систем нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд гарч байгаа аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд

Аудитлагдсан санхүүгийн тайлангаас

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

28.2 Холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ:

Ногдол ашигтай холбоотой ажил гүйлгээ.

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэгж хувьцаанд ногдох ашиг	Зарласан ногдол ашиг	Суутгуулсан ХХОАТ 5%	Хүлээн авсан ногдол ашиг
Э-Транс ХХК	23,100,000	5.00	115,500,000.00	11,550,000.00	103,950,000.00
Би Ди Сек ХК	13,179,669	5.00	65,898,345.00	6,589,834.50	59,308,510.50
Тасган инвест ХХК	5,092,835	5.00	25,464,175.00	2,546,417.50	22,917,757.50
Би Ди Пи Эй Эф ХХК	1,818,857	5.00	9,094,285.00	1,818,857.00	7,275,428.00
Бусад	3,008,639	5.00	15,043,195.00	1,732,864.00	13,310,331.50
ДҮН	46,200,000		231,000,000.00	24,237,973.00	206,762,027.00

28.3 Бусад холбоотой талууд

Бусад холбоотой талуудад хувьцаа эзэмшигчид болон тэдний гэр бүлийн гишүүд болон гишүүдтэй холбоотой байгууллагууд, компанитай адил нэг захирал эсвэл гол удирдлагатай байгууллагууд, захирал болон гол удирдлага мөн тэдгээрийн гэр бүлийнхэнтэй холбоотой байгууллагууд хамаарна.

29 Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс

29.1 Хууль, эрх зүй

Компани нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад ч хуулийн аливаа зарга маргаан болон гомдолтой холбогдож болно. Хэрэв аливаа зарга маргаан, гомдол гарснаас ямар нэгэн үүрэг хариуцлага үүсвэл энэ нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

29.2 КОВИД-19-ийн нөлөө

КОВИД-19 дэгдэлтээс сэргийлэх үүднээс дэлхийн улс орнуудын Засгийн Газар, түүний дотор Монгол Улсын Засгийн Газар эдийн засгийн үйл ажиллагаа, худалдааны нөхцөл байдалд ихээхэн хэмжээний нөлөө үзүүлэхүйц хязгаарлалтын арга хэмжээнүүдийг авсан. Үүний үр дүнд, дэлхийн олон улс орнууд, түүний дотор Монгол Улсын эдийн засаг нэлээд удааширч, үүнтэй холбоотой сөрөг үр дагавруудтай тулгарсан.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улс 2020 болон 2021 онд хөл хорио тогтоох, хил хаах, улс хоорондын зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, хилээр нэвтрүүлэх бараа бүтээгдэхүүний хяналт шалгалтыг сайжруулах зэрэг олон төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. Тэвэрлэлтийн удаашрал, хүмүүсийн хөдөлгөөний хязгаарлалт, бизнесийн үйл ажиллагааны ажлын цагийг багасгасан зэрэг нь тус улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж, үүнээс шалтгаалан 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 5.4 хувиар буурсан байна. Монгол Улсын Засгийн Газраас эдийн засгийг дэмжих зорилгоор дараах ажлуудыг эхлүүлсэн бөгөөд үүнд аж ахуйн нэгж, иргэдэд татварын хөнгөлөлт, ихэнх өрхүүдэд татаастай эсвэл үнэгүй эрчим хүчээр хангах, эдийн засгийн бусад томоохон дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх, Засгийн Газрын Яамдууд болон зохицуулагч байгууллагууд нь санхүүгийн байгууллагуудыг бизнес эрхлэгчид болон иргэдийн хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулахыг дэмжих зэрэг багтсан.

Цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд Компани нь цар тахлын хямралын үеэр эрсдэлийн менежментийн хүрээг өргөжүүлж, компанийн үйл ажиллагаа, зорилгод гарч болзошгүй сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах зорилготой менежментийн бодлогыг хэрэгжүүлсэн. Компани нь ажилчдад хорио цээрийн дэглэмийн үед цалин хөлс олгох, вакцинжуулалтад хамруулах, ажлыг зохион байгуулж байна. Компани нь эрсдэлийг хянаж, гарч ирж буй аюул заналхийлэлд дүн шинжилгээ хийж, үйлдвэрлэл, ложистикийн системийн аюулгүй байдлын талаарх мэдээлэл, шинжлэмжийг тасралтгүй ханган ажиглаж байна.

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2021 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2022.03.31

Борхуйн тал

*Хэлэлцэх
асуудал 2*

*Компанийн 2021 оны
үйл ажиллагааны
тайлан*

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 12 дугаар сарын 31		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117636		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	БиДиСек ХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн	338,700,064.95
		Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,814,828,073.79
		Нийт хөрөнгийн дүн	5,153,528,138.74

		Богино хугацаат өр төлбөрийн дүн	54,847,931.49
		Өр төлбөрийн нийт дүн	54,847,931.49
		Эзэмшигчдийн өмчийн дүн	5,098,680,207.25
		Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	5,153,528,138.74
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого (цэвэр)	1,416,649,910.00
		Нийт ашиг (алдагдал)	1,416,649,910.00
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	293,073,228.86
		Татварын дараах ашиг (алдагдал)	262,664,671.72
		Нийт орлогын дүн	262,664,671.72
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч	4,620,000,000.13
		Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00
		Эздийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00
		Хуримтлагдсан ашиг	(450,177,872.88)
		Нийт дүн	5,098,680,207.75
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	1,630,815,457.00
		Мөнгөн зарлага (-)	1,122,054,130.18
		Цэвэр мөнгөн гүйлгээ	508,761,326.82
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	-
		Мөнгөн зардагын дүн (-)	334,762,027.50
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(178,415,235.66)

		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(334,762,027.50)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,415,936.34)
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	237,346,410.75
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт		

1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/					
	Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн 2021 оны 3 сарын 31-ний өдрийн 2022/22 тоотор аудитын дүгнэлт, тайлан, удирдлагын захидлыг хүргүүлсэн.					
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл					
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/					
	д/д	Орлогын нэр	Бизнес төлөвлөгөө 2021	Биелэлт	Зөрүү	Тайлбар
	1	Ачилтын орлого	18,600.00	96,913.62	78,313.62	Бизнес төлөвлөгөөгөөр барилгын материалын ачилтыг хийгдэхгүй гэж үзэж байсан ба 2021 онд задгай вагоноор краны ачилтыг хийсэн нь өсөлтөнд нөлөөлсөн
	2	Гарах хуудасны орлого	314,000.00	752,232.07	438,232.07	Гарах хуудасны төлбөрийг нэмэгдүүлсэн ба манай хяналтын бүсэд орж ирэх ачаа барааны тоо нэмэгдсэн
	4	Хадгалалын орлого	418,600.00	485,250.27	66,650.27	Агуулахын хадгалалт тодорхой хэмжээнд хэвийн байсан бөгөөд агуулахаас бас нэлээн ачаа гарсан тул хадгалалтын хураамж нэмэгдсэн.
	5	Түрээсийн орлого	53,909.10	57,818.19	3,909.08	2020 оны дутуу 2021 оны Түрээсийн төлбөрийг бүрэн төлүүлсэн ба манай хяналтын бүсийн үйл ажиллагаа зогссон тул 2021.10-р сараас төлбөрийг 50 хувь хөнгөлсөн.
	6	Бусад орлого	225,916.30	85,208.65	(140,707.65)	Үйл ажиллагаа доголдолтой байсан учраас бусад үйл ажиллагаа багассан

2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт		
	Хөрөнгийн байдлын үнэлгээ		
	Төрөл	Үзүүлэлт	
		Дүгнэлт	
		2021 он	
	Хөрөнгийн өсөлтийн хурд	98.58%	Нийт хөрөнгөнд өсөлт үзүүлэхүйц өөрчлөлт хийгдээгүй байна.
	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	6.56%	Эргэлтийн хөрөнгийн эзлэх жин бага байгаагаас авч үзэхэд хөрөнгийн хөрвөх чадвар муу ба нийт хөрөнгийн 94%-ийг үндсэн хөрөнгө эзлэж байна.
	Элэгдлийн хувь		
	Санхүүгийн байдлын үнэлгээ		
	Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
		2021 он	
	Ажлын капитал	283,586,211.00	Ажлын капитал сайн.
	Ажлын капиталын оролцоо	83.88%	Эргэлтийн хөрөнгийн 83.88% хувийг байнгын капиталгаар санжүүжүүлж байна.
	Эргэлтийн харьцаа	6.2	Эргэлтийн хөрөнгөөр БХӨТ-ийг барагдуулах чадвар сайн.
	Бие даалтын коеф	98.94%	Бие даан үйл ажиллагаа явуулах чадвар өндөр.
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл		
	Компанийн үйл ажиллагаанд өнөөдрийн байдлаар цар тахалтай холбоотой хорио цээрийн асуудал ихээхэн нөлөө үзүүлж байна. 2021 оны 10 сарын 15-нд БНХАУ хилээ хааснаар тус компанийн үйл ажиллагаа бүрэн зогссон. Засгийн газрын 2021 оны 27-р тогтоолоор Замын-Үүд боомтыг тусгай горимд оруулснаас хойш чингэлэг тээврийн үйл ажиллагаа явагдаж байгаа боловч тус компанид өнөөдрийн байдлаар шилжүүлэн ачилт хийгдээгүй ба харин шинэ болон дугаар аваагүй импортын машин техник, тоног төхөөрөмжүүд тус гаалийн хяналтын бүс болон Дардан ложистикс ХХК-ны гаалийн хяналтын бүсүүдэд ээлжээр орж хяналт шалгалтанд хамрагдаж байгаа болно. 2021 оны		

жилийн эцсийн байдлаар төмөр замаар шилжүүлэн ачсан вагоны тоо 344, түүнээс олсон орлого 96,913.6 төгрөг /өмнөх оны ачилтаас олсон орлого нь их байгаа нь шилжүүлэн ачилт хийлгэх ачааны төрөл голцуу кранаар хийгдэх ажил байсан ба краны тариф өнгөрсөн оныхоос нэмэгдсэнээс шалтгаалсан /, гаалийн хяналтын бүсэд орсон тээврийн хэрэгслийн тоо 14677, хяналтын бүсэд орсон тээврийн хэрэгслийг хадгалсны хураамж 486,176.42 төгрөг, гаалийн баталгаат агуулахад ачаа бараа хадгалсны төлбөр 721,125.90 төгрөгний орлоготой байсан зэрэг гол ажил үйлчилгээнүүд өмнөх оныхоос өссөн нь хил хаагдаж импорт, экспорт зогссон ч үйл ажиллагааны орлого буураагүй байна. 2022 онд тухайн нөхцөл байдалтай уялдуулан зарим төрлийн тоног төхөөрөмж шинээр авах, гааль хяналтын байгууллагаас хяналтын бүсийн талаар тавьж байгаа шаардлага бодлогын хүрээнд MNS 5832:2007 стандартад нийцүүлэн хяналтын бүсийн шинэчлэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэх, компанийн маркетинг, менежментийг сайжруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

д/д	Орлогын нэр	2020 он	2021 он	Зөрүү	Өсөлт бууралт
1	Ачилтын орлого	78,103.04	96,913.61	18,810.57	24.1%
2	Хадгалалт болон гарах хуудас	943,746.3	1,237,482.33	293,736.03	31.1%
3	Түрээсийн орлого	41,818.8	57,818.18	15,999.38	38.3%
4	Бусад орлого	180,100.1	85,822.27	-94,277.83	-1.1 дахин буурсан

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Худалдаа хөгжлийн банкнаас 2018 оны 12-р сарын 17-нд 5 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн хүүтэйгээр авсан 200,000,000 сая төгрөгний зээлийг бүрэн төлж барагдуулсан байна.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компаниас цалин урамшуулал авдаггүй болно. Тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс тухайн компанийн хувьцааг эзэмшдэг гишүүн байхгүй, санхүүгийн жилийн хугацаанд гүйцэтгэх захирал 22,000.0 төгрөгийн цалин урамшуулал авсан байна.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр цахимаар зохион байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

Д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	Дээд	Баянцемент ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
3.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Гүйцэтгэх захирал
6.	Шараагийн Шинэбаяр	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, хөрөнгө оруулалтын менежер
7.	Хасагийн Бат-Эрдэнэ	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Интерсорс ХХК, Захирал
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Лайф ис Гүүд Монголиа ХХК, нягтлан бодогч
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Хувиараа

ТУЗ-ын даргаар Э.Батболд, аудитын хороонд Х.Бат-Эрдэнэ / дарга /, гишүүд Ж.Энхтулга, Б.Лхагвадорж, нэр дэвшүүлэх хороонд Э.Батболд / дарга /, гишүүд Х.Бат-Эрдэнэ, Ч.Оргил, цалин урамшууллын хороонд Д.Даянбилгүүн / дарга /, гишүүдэд Ч.Оргил, Ж.Энхтулга нар сонгогдон ажиллаж байна.

	Компанийн удирлагаас менежер Х.Батхишиг нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөндсөн ба үүнээс өөрөөр бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.				
	д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
	1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
	2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
	3.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
	4.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.
	5.	Содномцэрэн Ганбат	Дотоод ажил хариуцсан ажилтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд, хуульч цагдаагийн байгууллагын ажилтан	2014 оноос хойш ажиллаж байна.
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл				
	Тус компанийн үйл ажиллагаа нь төмөр замын байгууллага, хилийн боомтын үйл ажиллагаа зэргээс бүрэн хамааралтай тул тухайн салбарын үйл ажиллагаа, нөхцөл байдлаас шалтгаалан өсч буурч байдаг. Үүнээс гадна тухайн бүс нутагт адил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудын өрсөлдөх чадамж нэмэгдэж байгаа нь тухайн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх байдал харагдаж байгаа юм. Өмнөд хөршид гарсан цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тус компанид шилжүүлэн ачилт хийгдэх ачаа бараа / барилгын материал / орж ирэхгүй байгаа мөн гаалийн бүрдүүлэлт хийгдэх ачаа бараа / машин техник, тоног төхөөрөмжөөс бусад / орохгүй байгаа ба машин техник, тоног төхөөрөмж ч хязгаарлалттай тоогоор орж ирж байгаа нь компанийн хувьд эрсдэлтэй нөхцөл байдалд байна гэж үзэж байна.				
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/				
	Тус компани нь нийт 363 хувьцаа эзэмшигчтэй, Э-Транс ХХК / нийт хувьцааны 50 % /, БиДиСек ХК / нийт хувьцааны				

	28,5% /, Тасган инвест ХХК / нийт хувьцааны 11,08% / эзэмшдэг 5%-иас дээш хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчидтэй.
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Төсөл хэрэгжүүлэхээр хувьцаа гаргаагүй болно.
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	2020 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5 төгрөг байхаар нийт 42,600,00 хувьцаанд 231,000,000 төгрөгийн ногдол ашгийг 2021 оны 07 дугаар сарын 30-ны дотор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжин төвөөр дамжуулан тараахаар ТУЗ-аар шийдвэрлэсэн бөгөөд 4 аж ахуйн нэгж компанийн дансаар дамжуулан ногдол ашгаа авахаар хүсэлт ирүүлсний дагуу Э-Транс ХХК, БиДиСек ХК, Тасган инвест ХХК, Би Ди Пи Эй Эф ХХК-уудын ногдол ашгийг шилжүүлж бусад гадаад, дотоодын иргэн, аж ахуйн нэгж, иргэдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд шилжүүлэн тараалгаж ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 01-ний 01 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 1 төгрөг байхаар 46,200,000 төгрөгийг хувьцаа эзэмшигчид хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд энэхүү ногдол ашгийг мөн холбогдох хууль журмын дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тараах болно.
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Тайлант хугацаанд Компанийн дотоод журам дахь нийгмийн хамгаалал, тэтгэмж тусламжтай холбоотой заалтуудад нэмэлт оруулан нийгмийн хамгааллын заалтуудыг нэмсэн. Дотоод журмын дагуу тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 4 ажилтанг ахмадын баяраар хүлээн авч гарын бэлэг, 1 ахмад ажилтанд бүрэн гэр зэргийг өгсөн ба үүнээс гадна 9 ажилтанд 4,888.0 төгрөгийн тусламжийг нийгмийн хариуцлага, хамгааллын хувиар олгосон байна. Мөн Замын-Үүд сумын 1-р багийн хөгжлийн бэрхшээлтэй болон амьжиргааны баталгаажих түвшин доогуур амьдралтай, хагас бүтэн өнчин 30 хүүхдэд хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр бэлэг өгч ажилласан. Байгал орчин хамгаалах чиглэлээр компанийн орчмийн хог хаягдлыг сар бүрийн эхний 7 хоногт цэвэрлэх ажлыг тогтмолжуулж хөрсний эвдрэл элсний нүүдлээс сэргийлэх зорилгоор эзэмшлийн газартаа 2 төрлийн 30 ширхэг суулгац тарьж ургуулсан.
	Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Хэлэлцэх асуудал 3

*Компанийн 2021 оны үйл
ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах
зөвлөлийн дүгнэлт*



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2021 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГАРГАСАН ДҮГНЭЛТ

2022.02.25

Улаанбаатар хот

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж дараах дүгнэлтийг өгсөнг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Э-Транс ложистикс Хувьцаат компани нь 2021 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагт ихээхэн хүндрэл бэрхшээл учирсан, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, экспорт, импортын ачаа бараа зогсонго байдалтай байсан зэрэг маш хүнд нөхцөл байдалд компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, зорилгыг хангахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллажээ гэж төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

Компани нь оны эхэнд ихээхэн эерэг үр дүнтэй бүрэн хүчин чадлаараа ажиллаж байсан ч 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс үндсэндээ бүрэн зогсолт хийсэн байх ба энэхүү байдал 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл үргэлжилж тодорхой хэмжээнд үйл ажиллагаануудаас олж байсан орлого тасалдсан бөгөөд хилээр чингэлгийн тээвэр явагдаж эхлэхэд тухайн компаниас өөрсдийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадалд тохируулан чингэлэг тээврийн хяналтын бүсээрээ дамжуулахаар ярилцаж шийдвэрлүүлэн 37 чингэлэг шилжүүлэн ачсан боловч гааль, мэргэжлийн хяналтын байгууллагаас зарим шаардлагыг тавьж энэхүү ажлыг зогсоожээ.

Төмөр замаар шилжүүлэн ачих ачаа мөн хилийн асуудлаас болж орж ирэхгүй байгаа боловч хорио цээрийн дэглэм тавигдахаас өмнө төмөр замаар шилжүүлэн ачих ачаа барааны тоо нэлээн өсөх хандлагатай байсан нь 10 сарын 15-ны байдлаар нийт 344 вагонд ачаа шилжүүлэн ачиж 96,913.6 төгрөгний орлого олсон байгаагаас харагдаж байна. / 2020 онд төмөр замаар 565 вагон ачаа шилжүүлэн ачиж / 221 вагон нь цемент / 78,103.04 төгрөгийн орлоготой байсан /. Энэ жилийн хувьд автокранаар задгай вагонд төмөр шилжүүлэн ачих үйлчилгээний тоо хэмжээ ихссэн ба энэхүү үйлчилгээний хураамжийг тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нэмсэн байсан нь шилжүүлэн ачилтын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Үүнээс гадна хяналтын бүсийн үйл ажиллагаа, гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа өмнөх жилийн мөн үеэс өндөр ачаалалтай ажилласан нь тухайн үйлчилгээнээс олсон орлого 31-38 хувиар өссөнөөс харагдаж байна. Хил хаахаас өмнө тухайн хяналтын бүсэд 14677 тээврийн хэрэгсэл нэвтэрч хяналтын бүсэд орсон тээврийн хэрэгслийг хадгалсны хураамж 486,176.42 төгрөг, гаалийн баталгаат агуулахад ачаа бараа хадгалсны хураамж 721,125.90 төгрөг нийт үндсэн үйл ажиллагаанаас 1,392,214.12 төгрөгний орлоготой ажилласан байна. Харин бусад үйл ажиллагаанаас олсон орлого нэлээн хэмжээгээр буурсан нь зарим үйлчилгээний доголдлоос үүсэлтэй байна. Хил хаагдаж үйл ажиллагаа бүрэн зогссон ч үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого өмнөх жилийн мөн үеийнхтэй ижил хэмжээнд байсан нь санхүүгийн жилийн тайлангаар 262,398,749.26 төгрөгийн цэвэр ашигтай гарсанаар харагдаж байна. Иймд компани ашигтай ажилласан байна гэж үзэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нэгж хувьцаанд 1 төгрөг байхаар 46,200,000 төгрөгний ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэлээ. Гэхдээ нэгж хувьцаанд ногдох ашгийг нэмэгдүүлэх боломжтой байсан ч компанийн цаашдын үйл ажиллагааны төлөв, цар тахлын нөхцөл байдлыг тооцон үзэж дээрх шийдвэрийг гаргасан болно.

Өмнөх жилийн бизнес төлөвлөгөөнд заагдсан зарим ажил үйлчилгээнүүд хил гаалийн нөхцөл байдлаас шалтгаалан хийгдээгүй байгаа бөгөөд зайлшгүй шаардлагатай агуулахын шинэчлэлт тохижуулалтын ажлыг энэ жилдээ хийж ашиглалтанд оруулах талаар болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар яригдсан 2022 онд хийх боломжтой гэж үзсэн ажлуудаа сайтар төлөвлөн хийж гүйцэтгэх, цар тахлын нөхцөл байдалд тохируулан үйлчилгээнийхээ хүртээмж, төрөл, цар хүрээг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудыг хийж эрсдэлийн удирдлагыг хангаж ажиллаж байхыг гүйцэтгэх удирдлагад зөвлөж ажиллалаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

*Хэлэлцэх
асуудал 4*

*Компанийн 2021 оны
стратегийн төлөвлөгөө*



ӨСӨЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Компани: Э-Транс ложистикс ХК

Огноо: 2022.03.14

А. ӨСӨЛТИЙН ЧИГЛЭЛ:

5 ЖИЛИЙН ЗОРИЛТ	3 ЖИЛИЙН ДАРААХ ДҮР ЗУРАГ	ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ																			
<p>Хугацаа: 2027.12.31</p> <p>Жилдээ 2 тэрбумын орлоготой, 30%-ийн цэвэр ашиг олдог болсон байна.</p>	<p>Хугацаа: 2025.12.31</p> <p>Дүр зураг:</p> <ul style="list-style-type: none"> Бүрэн автоматжуулсан шилжүүлэн ачилтын цогцолбортой Орон нутагтаа болон бусад нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаараа танигдсан ША, ГХБ, БА-аар үйлчлүүлэгчдийн 80 % нь тус компаниар үйлчлүүлэх сонирхолтой Нэгдсэн удирдлагаар хангадаг тогтолцоотой Маркетингийн бие даасан багтай Хөргөлтийн болон вакуумжсан 2-3 агуулахтай Цайны газраар үйлчлүүлэгчдийн тоо өссөн, Замын-Үүд суманд хоол үйлдвэрлэлээрээ танигдсан Үйл ажиллагаандаа мөрддөг урамшуулал, хөнгөлөлтийн цогц бодлоготой болсон 	<p>Хугацаа: 2022.12.31</p> <p>Гарцын үзүүлэлтүүд: Орлого: 1,6 тэрбум Ашиг: 300 сая Өсөлт: 14,3 %</p> <p>Жилийн гол үр дүнгүүд:</p> <table border="1"> <tr> <td>1</td> <td>Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80%-д хүргэсэн.</td> </tr> <tr> <td>2</td> <td>Удирдлагын багийнхан ур чадварын хөтөлбөрт хамрагдсан.</td> </tr> <tr> <td>3</td> <td>Компанийн маркетингийн ажлыг тогтмолжуулсан.</td> </tr> <tr> <td>4</td> <td>Шилжүүлэн ачилт, ГХБ, БА дахь үйлчилгээ нэмэгдсэн.</td> </tr> <tr> <td>5</td> <td>Бренд нэр төрлийн хоолтой болсон.</td> </tr> <tr> <td>6</td> <td></td> </tr> </table>	1	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80%-д хүргэсэн.	2	Удирдлагын багийнхан ур чадварын хөтөлбөрт хамрагдсан.	3	Компанийн маркетингийн ажлыг тогтмолжуулсан.	4	Шилжүүлэн ачилт, ГХБ, БА дахь үйлчилгээ нэмэгдсэн.	5	Бренд нэр төрлийн хоолтой болсон.	6								
1	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80%-д хүргэсэн.																				
2	Удирдлагын багийнхан ур чадварын хөтөлбөрт хамрагдсан.																				
3	Компанийн маркетингийн ажлыг тогтмолжуулсан.																				
4	Шилжүүлэн ачилт, ГХБ, БА дахь үйлчилгээ нэмэгдсэн.																				
5	Бренд нэр төрлийн хоолтой болсон.																				
6																					
АСУУДАЛ БА БОЛОМЖ																					
<table border="1"> <tr> <td>1</td> <td>Цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмтэй байгаа нь ашгийг бууруулж байна.</td> </tr> <tr> <td>2</td> <td>Удирдлагын багийн ур чадвар дутмаг.</td> </tr> <tr> <td>3</td> <td>Ур чадвар дутмагаас шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар санал санаачилга байдаггүй.</td> </tr> <tr> <td>4</td> <td>Маркетингийн төрөл бүрийн идэвхижүүлэлт хангалтгүй, огт хийдэггүй.</td> </tr> <tr> <td>5</td> <td>Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах байдал тааруу.</td> </tr> </table>	1	Цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмтэй байгаа нь ашгийг бууруулж байна.	2	Удирдлагын багийн ур чадвар дутмаг.	3	Ур чадвар дутмагаас шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар санал санаачилга байдаггүй.	4	Маркетингийн төрөл бүрийн идэвхижүүлэлт хангалтгүй, огт хийдэггүй.	5	Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах байдал тааруу.	<table border="1"> <tr> <td>6</td> <td>Боомтын өргөтгөлийн ажил дуусаагүй байгаа тул хяналтын бүсэд нэвтрэх машины тоо өмнөх жилүүдийн хэмжээнд түүнээс ч өсөх боломжтой.</td> </tr> <tr> <td>7</td> <td>Тоног төхөөрөмж, агуулахын шинэчлэлт хийснээр шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой.</td> </tr> <tr> <td>8</td> <td>MNS 5832:2007 стандартын шаардлагыг хангаснаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдаж үйлчилгээ авах сонирхол нэмэгдэх боломжтой.</td> </tr> <tr> <td>9</td> <td>Маркетинг, менежмент сайжирснаар компанийн нэр хүнд өсөх боломжтой.</td> </tr> <tr> <td>10</td> <td></td> </tr> </table>	6	Боомтын өргөтгөлийн ажил дуусаагүй байгаа тул хяналтын бүсэд нэвтрэх машины тоо өмнөх жилүүдийн хэмжээнд түүнээс ч өсөх боломжтой.	7	Тоног төхөөрөмж, агуулахын шинэчлэлт хийснээр шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой.	8	MNS 5832:2007 стандартын шаардлагыг хангаснаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдаж үйлчилгээ авах сонирхол нэмэгдэх боломжтой.	9	Маркетинг, менежмент сайжирснаар компанийн нэр хүнд өсөх боломжтой.	10	
1	Цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмтэй байгаа нь ашгийг бууруулж байна.																				
2	Удирдлагын багийн ур чадвар дутмаг.																				
3	Ур чадвар дутмагаас шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар санал санаачилга байдаггүй.																				
4	Маркетингийн төрөл бүрийн идэвхижүүлэлт хангалтгүй, огт хийдэггүй.																				
5	Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах байдал тааруу.																				
6	Боомтын өргөтгөлийн ажил дуусаагүй байгаа тул хяналтын бүсэд нэвтрэх машины тоо өмнөх жилүүдийн хэмжээнд түүнээс ч өсөх боломжтой.																				
7	Тоног төхөөрөмж, агуулахын шинэчлэлт хийснээр шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой.																				
8	MNS 5832:2007 стандартын шаардлагыг хангаснаар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал хангагдаж үйлчилгээ авах сонирхол нэмэгдэх боломжтой.																				
9	Маркетинг, менежмент сайжирснаар компанийн нэр хүнд өсөх боломжтой.																				
10																					

Б. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ:**УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хугацаа: 2022.06.30

Гарцын үзүүлэлтүүд:

Орлого: 362 сая

Ашиг: 65 сая

Өсөлт: 3,1%

Ч/Д	Компанийн төслүүд	Хариуцагч
1	Шинэ тоног төхөөрөмж авах	Ерөнхий нягтлан бодогч
2	Брэндийн нэр төрлийн хоол үйлдвэрлэж хоолны цэсэнд оруулсан.	Ахлах тогооч
3	ГХБүсийн талбайг стандартын шаардлагад нийцүүлсэн.	Гаалийн хяналтын бүсийн эрхлэгч
4	Шинэ вэб хуудас ашиглалтанд оруулсан.	Дотоод ажилтан
5	Маркетингийн ажлын зохион байгуулалтыг эхлүүлсэн.	Дотоод ажилтан

Ч/Д	Ерөнхий нягтлан бодогч
1	Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа гаргасан.
2	Чингэлэг ачих төхөөрөмж авсан.

Ч/Д	Ахлах тогооч
1	3 нэр төрлийн хоол шинээр цэсэнд орсон.
2	Хоол үйлдвэрлэлийн хугацааг багасгаж аль болох бэлэн хоол гаргах аргад шилжүүлсэн.

Ч/Д	Гаалийн хяналтын бүсийн эрхлэгч
1	ГХБ-ийг MNS 5832:2007 стандартад нийцүүлж зам талбайг засах ажлыг эхлүүлсэн.
2	Баталгаат агуулахын зориулалтыг өөрчлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.

Ч/Д	Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан
1	Шинэ веб хуудас ашиглалтанд оруулсан.
2	Маркетинг, менежментийн чиглэлээр ажиллах ажилтантай болсон.
3	Вэб хуудастай уялдсан гар утасны аппликейшн зохиолгох ажлыг эхлүүлсэн.
4	

Ч/Д	Хариуцагч
1	
2	
3	
4	

Хэлэлцэх асуудал 5

*Мөлөөлөн удирдах
зөвлөлийн цалин
урамшууллын төсөв*



2022 оны ТУЗ-ын зардлын төсөв

	Зардлын нэр	Нэгжийн зардал	Зардлын дүн / төгрөг /
1	ТУЗ-ын гишүүдийн цалин	-	-
2	ТУЗ-ын нарийн бичгийн цалин	240,000*4	960,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	1,000,000	1,000,000
4	ТУЗ-ын хурлын зардал	1,000,000	1,000,000
5	Томилолтын зардал	1,000,000	1,000,000
6	Бичиг хэргийн зардал	100,000	100,000
7	Бусад / ХЭХ-ын зар гаргах /	500,000	500,000
	Дүн		4,560,000

Хэлэлцэх асуудал 6

*Мөлөөлөн удирдах
зөвлөлийн энгийн болон
хараат бус гишүүнд нэр
дэвшигчид*



**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
ердийн гишүүнд нэр дэвшигч
Чулуун овогтой Амарсанаа**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуун овогтой Амарсанаа
Төрсөн он: 1961 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Э-Транс Ложистикс ХК
гүйцэтгэх захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1969	1979
2	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль	Уулын инженер	1979	1984
3	БНСЧС улсын Коопщинице мэргэжил дээшлүүлсэн		1989	1990


3. Ажлын туршлага

1984-1985 онд Бугантын алтны үйлдвэрт засварчин, туслах эксаваторчин
1985-1991 онд Цагаан дэлийн уурхай, ерөнхий механик
1991-1995 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэр, Ерөнхий инженер дарга
1995-2002 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэрийн харьяа Хавчуугийн алтны уурхай, ерөнхий инженер, дарга
2002-2011 онд Э-Транс ХХК, гүйцэтгэх захирал
2011 оноос Э-Транс Ложистикс ХК, гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
ердийн гишүүнд нэр дэвшигч
Энхболд овогтой Батболд**

1. Товч танилцуулга

Овог нэр: Энхболд овогтой Батболд
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Баянцемент ХХК-ны
гүйцэтгэх захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1995	2004
2	Тайваны их сургууль	Эрх зүйч	2008	2014

3. Ажлын туршлага

2014-2015 онд Тайван дахь худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газарт туслах ажилтан
2016 оноос Баянцемент ХХК-ны ерөнхий менежер
2018 оноос Э-Транс ХХК-ны дэд захирал
2020 оноос Баянцемент ХХК-ны гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
ердийн гишүүнд нэр дэвшигч
Чулуун овогтой Энхболд**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуун овогтой Энхболд
Төрсөн он: 1967 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн
ерөнхий захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

3. Ажлын туршлага

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин

1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга

1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга

1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
ердийн гишүүнд нэр дэвшигч
Данзан овогтой Даянбилгүүн**

1. Товч танилцуулга

Овог нэр: Данзан овогтой Даянбилгүүн
Төрсөн он: 1976 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, гүйцэтгэх
захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1984	1994
2	Европ хэлний дээд сургууль	Бизнесийн эдийн засагч	1994	1998
3	СЭЗДСургууль	Бизнесийн удирдлага, магистр	2003	2005

3. Ажлын туршлага

1994-1995 онд Эдийн тэнгэр банк – оператор, нягтлан бодогч,
1995-1997 онд УИХ-ын тамгийн газар – гишүүний орон тооны ажилтан

1997-1999 онд “БиДиСек” ХХК – салбарын менежер

1999 оноос одоог хүртэл “БиДиСек” ХК-ны гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
ердийн гишүүнд нэр дэвшигч
Шараа овогтой Шинэбаяр**

1. Товч танилцуулга

Овог нэр: Шараа овогтой Шинэбаяр
Төрсөн он: 1979 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК,
менежер



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1991	2001
2	Сэрүүлэг дээд сургууль	Бизнесийн удирдлага	2001	2005

3. Ажлын туршлага

2007 оноос одоог хүртэл БиДиСек ҮЦК ХК-нп хөрөнгө оруулалтын алба, менежер

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
ердийн гишүүнд нэр дэвшигч
Бүрэнмэнд овогтой Лхагвадорж**

1. Товч танилцуулга

Овог нэр: Бүрэнмэнд овогтой Лхагвадорж
Төрсөн он: 1976 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, тэргүүн
дэд захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	ШУТИС	Нефтийн инженер	1993	1997

3. Ажлын туршлага

1997 оноос БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
хараат бус гишүүнд нэр дэвшигч
Хасаг овогтой Бат-Эрдэнэ**

1. Товч танилцуулга

Овог нэр: Хасаг овогтой Бат-Эрдэнэ
Төрсөн он: 1980 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Интерсорс инк ХХК,
Захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	МУИС	Дээд, бизнесийн удирдлага	2001	2005

3. Ажлын туршлага

2007-2010 онд Эс Би Ложистикс ХХК, тээврийн менежер
2011-2014 онд Гранд ложистикс ХХК, гүйцэтгэх захирал
2014 оноос Интерсорс инк ХХК, захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн
хараат бус гишүүнд нэр дэвшигч
Чулуунбаатар овогтой Оргил**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуунбаатар овогтой Оргил
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “МГТБҮ” ТӨХХК,
ГХХ-ийн дарга



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	1-р дунд сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Хан-Уул дээд сургууль	Бакалавр	2005	2010
3	Chinese Culture University	Магистр	2012	2014

3. Ажлын туршлага

2015-2017 онд ССХ, судлаач
2019-2019 онд БНЭУ-ын элчин сайдын яам, Маркетингийн АД
2019 оноос МГТБҮ ТӨХХК, ГХХ-ийн дарга

**“Э-Транс Логистикс” ХК-ийн ТУЗ-ийн
хараат бус гишүүнд нэр дэвшигч
Жаргалсайхан овогтой Энхтулга**

1. Товч танилцуулга

Овог нэр: Жаргалсайхан овогтой Энхтулга
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Лайф ис Гүүд Монголиа ХХК,
Нягтлан бодогч



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	СЭЗДСургууль	Бизнесийн удирдлага	2005	2010

3. Ажлын туршлага

2011-2011 онд МҮХАҮТанхим, Туслах ажилтан
2014-2015 онд Лайф ис Гүүд Монголиа ХХК, Худалдан авалтын зөвлөх
2015-2017 онд Лайф ис Гүүд Монголиа ХХК, Гүйцэтгэх захирал
2017 оноос Лайф ис Гүүд Монголиа ХХК, Нягтлан бодогч

*Хэлэлцэх
асуудал 7*

*Жогдол ашгийн талаар
гаргасан шийдвэр*





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022.08.01

№ 01

Борхойн тал

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Э-Транс Ложистикс" ХК-ны 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 17.6 хувь буюу нэгж хувьцаанд 1 төгрөгөөр 46,200,000 хувьцаанд нийт 46,200,000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилах ажлыг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2022 оны 12 сарын 31-ний дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД